



**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗАРТ ХАМААРАХ ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**УЛААНБААТАР ХОТ
2023 он**

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ ХАМААРАХ
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД
ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
/2023 оны эхний хагас жилийн байдлаар/

2023.07.05

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн Ашигт малтмал, газрын тосны газраас хэрэгжүүлсэн тогтоол, шийдвэр, зүйл заалтуудын биелэлтийн явцад хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт гарган удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар гаргуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж ажиллав.

Эрх зүйн актын зүйл заалтыг тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр, нэг удаагийн үйлчлэлтэй бол шийдвэр гарсан өдрөөс хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өссөн дүнгээр тооцож гаргалаа.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 10 тогтоол шийдвэрийн 14 заалтыг хяналтад авснаас УИХ-ын байнгын хорооны 1, Ерөнхийлөгчийн зарлигийн 3, Засгийн газрын тогтоолын 8 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 1 заалтын биелэлтийг тус тус гарган, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Ашигт малтмал, газрын тосны газарт 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 14 тогтоол, шийдвэрийн заалтын 10 /71.4 хувь/ нь бүрэн биелсэн, 2 /14.2 хувь/ заалт хэрэгжих шатанд, 2 заалт АМГТГ-ын үндсэн чиг үүрэгт хамааралгүй буюу үнэлэх боломжгүй гэж дүгнэсэн бөгөөд биелэлтийн дүн дунджаар 95.0 хувьтай үнэлэгдэв.

Хууль зүйн байнгын хорооны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг тайлагнахдаа Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай Ашигт малтмал, газрын тосны газраас тусгайлсан гэрээ байгуулж ажилладаггүй бөгөөд Ашигт малтмал, газрын тосны газрын чиг үүрэгт хамаарахгүй тул үнэлгээнд оруулж тооцоогүй.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 362 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагыг томилох эрх бүхий этгээд, Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, гүйцэтгэх удирдлагад тус тус даалгаж, орон нутгийн өмч давамгайлсан

эрх бүхий этгээдэд зөвлөсөн тул Ашигт малтмал, газрын тосны газрын чиг үүрэгт хамаарахгүй тул нэгдсэн үнэлгээнд оруулж тооцоогүй болно.

Хүснэгт-1

| Эрх зүйн актын ангилал | Бүгд | Шийдвэрийн төрлөөр | | | | | | |
|------------------------|------------------------------------|--------------------|----------------|--------------------------------|-----------------------|---------------|----------------------------|-----------------------|
| | | МУ-ын хууль | УИХ-ын тогтоол | УИХ-ын байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | ЗГ-ын тогтоол | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | ЗГ-ын албан даалгавар |
| Тогтоол, шийдвэр | 11 | - | - | 1 | 3 | 7 | 1 | - |
| Заалт | 14 | - | - | 1 | 4 | 8 | 1 | - |
| Үнэлгээ | Биелсэн: 100% | 10 | - | - | 4 | 5 | 1 | - |
| | Хэрэгжих шатанд: 70% | 2 | - | - | - | 2 | - | - |
| | Хэрэгжилт хангалтгүй: 30% | - | - | - | - | - | - | - |
| | Хэрэгжээгүй: 0% | - | - | - | - | - | - | - |
| | Үнэлэх боломжгүй, хугацаа болоогүй | 2 | - | - | 1 | - | 1 | - |
| Үнэлгээ: % | 95.0 | - | - | - | 100.0 | 91.4 | 100.0 | - |

Дөрөв. Дүгнэлт

4.1. Ашигт малтмал, газрын тосны газарт 2023 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг дунджаар 95.0 хувиар үнэлэв. Үүнээс Ерөнхийлөгчийн зарлигийн биелэлт 100 хувь, Засгийн газрын тогтоолын биелэлт 91.4 хувь, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн биелэлт 100 хувийн биелэлттэй байна.

Тав. Зөвлөмж

5.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт дунджаар 95.0 хувьтай буюу АМГТГ-ын хэмжээнд тогтмол хэрэгжилттэй байгаа хэдий ч газрууд тогтоол шийдвэрийн биелэлтийг гаргахдаа хариуцлагатай хандаж, өөрсдийн салбар болон хэлтсийн биелэлтийн дундаж үнэлгээг харьцуулан аль түвшинд хэрэгжиж байгаа, мөн өмнөх тайлагналтаас гарсан өөрчлөлтийн дүнд шинжилгээ хийж ажиллахыг, мөн нэгжийн дарга нар тайланг нягтлан үзэж зөвшөөрсний үндсэн дээр ТЗУГ, ХШҮДАГ-т хүргүүлэхийг;

5.2. Нэг удаагийн шинж чанартай, хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, үйл ажиллагаа нь өөр төрийн захиргааны төв байгууллагад шилжсэн болон цаашид хэрэгжих боломжгүй болсон тогтоол шийдвэрүүдийг тухай бүрт нь хяналтаас хасуулах тал дээр анхаарч, ХШҮДАГ-тай хамтарч ажиллаж хэвшихийг;

5.3. Асуудал хариуцсан мэргэжилтэн хяналтад авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр дагавар, ажлын ахиц өөрчлөлтийн талаарх чанарын болон тоон мэдээллийг хөтөлж ажиллахыг тус тус зөвлөмж болгож байна.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ ХАМААРАХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хүснэгт-2

| Ший двэр д/д | Заа лт д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Нэгдсэн дүгнэлт | Үнэлгээ |
|---------------------------------------|------------------|--|---|--|-------------|
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | |
| 1 | 1 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | 3.20.. Уул уурхай, барилга, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээнд “Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. | Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай Ашигт малтмал, газрын тосны газраас тусгайлсан гэрээ байгуулж ажилладаггүй бөгөөд Ашигт малтмал, газрын тосны газрын чиг үүрэгт хамаарахгүй болно. | Х.Б |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | |
| 2 | 2 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, | Монгол улсын засгийн газрын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд “Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилт”-ийг хангах зорилгоор 2023 оны 1 дүгээр сарын 16-27-ны өдрүүдэд Насан туршийн боловсролын төвтэй хамтран Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, ур чадвар эзэмшүүлэх зорилготой сургалтад байгууллагын хэлтэс тус бүрээс хоёр албан хаагчдыг буюу нийт 18 албан хаагчид хамрагдсан ба үлдсэн албан хаагчдыг шат дараатайгаар сургалтад хамруулахаар сургалтын цаг авахаар “Насан туршийн боловсролын төв”-рүү хүсэлт тавьсан. Хуулийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын гадна хаяг болон Уул уурхай, газрын тосны төв лаборатори, АМГТГ-ын Төлөөлөгчийн газрын хаягийг тус бүр | 100% |

| | | | | | |
|----------------------|---|---|--|---|------|
| | | | холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | монгол бичиг болгож шинэчилсэн. Мөн удирдах албан тушаалтнууд өөрсдийн нэрийн хуудсаа монгол бичгээр шинэчлэн өөрчилж албан хэрэгцээндээ ашиглаж байна. Ашигт малтмал, газрын тосны газар нь энэ оны 9 дүгээр сард багтааж албан хаагчдын өрөө тасалгааны хаягийг Монгол бичиг болгохоор нийт 51 өрөөний хаягийг монгол бичиг рүү хөрвүүлж, хийлгэхээр захиалсан. | |
| 3 | 3 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Ашигт малтмалын тухай хуулийн 48.6-д заасан Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулах чиглэлд дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд: 1. Ашиглалтын үйл ажиллагааны 2022 оны албажсан тайлангаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 466 га талбайд 452,617 ширхэг мод тарьсан байна. 2. Ашиглалтын үйл ажиллагааны 2023 оны албажсан 361 төлөвлөгөөнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1362.1 га талбайд 6.3 сая мод тариулахаар тусгуулан ажилласан. | 100% |
| 4 | 4 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг | 2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. | АМГТГ-ын хурлын заал болон удирдах албан тушаалтнууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг өөрсдийн өрөөнд дээдлэн залсан байна. | 100% |
| | 5 | хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159 | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай Ерөнхийлөгчийн зарлигийн 4 дүгээр заалтыг АМГТГ-ын нийт албан хаагчдад танилцуулж, Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсан. | 100% |
| ЗГ-ын тогтоол | | | | | |

| | | | | | |
|---|---|--|---|---|-----|
| 5 | 6 | <p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7</p> | <p>5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:</p> <p>5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;</p> <p>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;</p> <p>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;</p> <p>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;</p> <p>5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.</p> | <p>Ашигт малтмал, газрын тосны газар нь Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын гадна хаяг болон Уул уурхай, газрын тосны төв лаборатори, АМГТГ-ын Төлөөлөгчийн газрын хаягийг тус бүр монгол бичиг болгож шинэчилсэн. Мөн удирдах албан тушаалтнууд өөрсдийн нэрийн хуудсаа монгол бичгээр шинэчлэн өөрчилж албан хэрэгцээндээ ашиглаж байна. 2023 оны 1 дүгээр сарын 16-аас эхлэн ажлын долоон өдөр 10:00-12:00 цаг хүртэл хурлын зааланд хэлтэс тус бүрийн тайлан төлөвлөгөө хариуцсан мэргэжилтнүүдийг монгол бичгийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан. Мөн удирдлагууд гадаад, дотоод томилолтоор ажиллахдаа нэрийн хуудсаа Монгол бичгээр хэвлүүлэн бэлдэж хэрэглэдэг болсон. Ашигт малтмал, газрын тосны газар нь энэ оны 9 дүгээр сард багтааж албан хаагчдын өрөө тасалгааны хаягийг Монгол бичиг болгохоор нийт 51 өрөөний хаягийг монгол бичиг рүү хөрвүүлж, хийлгэхээр захиалсан.</p> | 70% |
|---|---|--|---|---|-----|

| | | | | | |
|---|---|--|--|--|-----|
| 6 | 7 | <p>Бүтээгдэхүүн хуваах гэрээ цуцлах эрх олгох тухай 2022-09-05 Дугаар 2022_337</p> | <p>4. Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах ажлыг зохион байгуулж төлбөрийн үлдэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т, бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт тус тус даалгасугай.</p> | <p>Газрын тосны хайгуулын хэлтэстэй хамтран бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа дуусаж байгаа “Увс-1” талбайн гэрээлэгч “Монгол Гладвил Увс Петролиум” ХХК-ийн гэрээг дүгнэж уг гэрээг дуусгавар болгох, “Тариач-15” талбайн гэрээлэгч “Чайна голден Си Петролиум эксплорэйшн” ХХК бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн үндэслэлээр гэрээг цуцлах санал бичин УУХҮЯ-д хүргүүлэхээр ажиллаж байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээний үүргээ 2021-2022 онд биелүүлээгүй, уг гэрээнд заасан төлбөрөө бүрэн барагдуулаагүй нэр бүхий 9 гэрээлэгч аж ахуйн нэгжээс өмнөх жилүүдэд хуримтлагдсан төлбөрийн үлдэгдлийг нөхөн төлүүлэх ажлын хүрээнд уг аж ахуйн нэгжүүдээс төлбөр нэхэмжлэн захиргааны болон иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандаж 20 гаруй удаа нэхэмжлэл гаргаж ажилласан. Дээр дурдсан анхан шатны шүүхүүд “...нэхэмжлэгчийн оршин байгаа хаяг тодорхойгүй, тус харьяаллын биш байна” гэсэн шалтгаанаар буцаасан бөгөөд нэр бүхий 9 аж ахуйн нэгжээс нэхэмжилж буй нэхэмжлэлийн харьяаллыг тогтоолгохоор Улсын дээд шүүхэд хандсан болно.</p> | 70% |
| 7 | 8 | <p>Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2022-10-05 Дугаар 2022_362</p> | <p>2. 2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагыг томилох эрх бүхий этгээд, Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, гүйцэтгэх удирдлагад тус тус даалгаж, орон нутгийн өмч давамгайлсан эрх бүхий этгээдэд зөвлөсүгэй.</p> <p>2.1. Засгийн газрын шийдвэргүйгээр төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ бүх</p> | <p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 362 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагыг томилох эрх бүхий этгээд, Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, гүйцэтгэх удирдлагад тус тус даалгаж, орон нутгийн өмч давамгайлсан эрх бүхий этгээдэд зөвлөсөн тул Ашигт малтмал, газрын тосны газрын чиг үүрэгт хамаарахгүй болно.</p> | Х.Б |

| | | | | | |
|---|---|---|---|--|-------------|
| | | | <p>төрлийн шинэ гэрээ байгуулахыг зогсоох;</p> <p>2.2. Төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ болон төлбөрийг урьдчилан авч ашигласан гэрээний дагуу, эсхүл төлбөр нь нэн даруй хийгдэх ашигт малтмалын экспортыг валютын бодит орох урсгалыг нэмэгдүүлэхээр оновчтой зохион байгуулах;</p> <p>2.3. Ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой албаны болон байгууллагын нууцад хамааралтай гэрээ, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2022 оны 11 дүгээр сард багтаан нууцаас гаргаж, ил тод болгох арга хэмжээ авах, цаашид нууц гэрээ байгуулахгүй байх.</p> | | |
| 8 | 9 | Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц тогтоох тухай 2022-10-19 Дугаар 2022_378 | <p>2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т тус тус даалгасугай.</p> | <p>Засгийн газрын 378 дугаар тогтоолоор 2023 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нэр бүхий 54 аж ахуйн нэгж, үүнээс бүх төрлийн шатахууны 47, шатдаг хийн 6 аж ахуйн нэгжүүдтэй 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр “Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх тухай гэрээ”-г байгуулж, нөөцийн бүрдүүлэлт, тогтоол, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Засгийн газрын тогтоолоор компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээж гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдээс 7 хоног бүрийн пүрэв гаригт нөөцийн үлдэгдлийн мэдээ, тайланг хүлээн авч, нэгтгэн, УУХҮЯ болон Монгол банканд тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 138.2 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдэл</p> | 100% |

| | | | | | |
|---|----|---|---|---|------|
| | | | | <p>нөөцтэй байгаагаас А-80 автобензин 21 хоног, Аи-92 автобензин 31, дизель түлш 30 хоног, ТС-1 41 хоног, ШШХ 47 хоногийн тус тус үлдэгдэл, нөөцтэй байна.</p> <p>- Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан төлөвлөгөөний дагуу эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын БГД, СБД, СХД зэрэг дүүрэгт байрлах агуулах, шатахуун түгээх станцуудаас түүврийн аргаар 70 дээж авч, чанарын хяналтын шинжилгээ хийж бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажилласан.</p> | |
| 9 | 10 | Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц тогтоох тухай 2022-10-19 Дугаар 2022_378 | <p>2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т тус тус даалгасугай.</p> | <p>Засгийн газрын 378 дугаар тогтоолоор 2023 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нэр бүхий 54 аж ахуйн нэгж, үүнээс бүх төрлийн шатахууны 47, шатдаг хийн 6 аж ахуйн нэгжүүдтэй 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр “Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх тухай гэрээ”-г байгуулж, нөөцийн бүрдүүлэлт, тогтоол, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Засгийн газрын тогтоолоор компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээж гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдээс 7 хоног бүрийн пүрэв гаригт нөөцийн үлдэгдлийн мэдээ, тайланг хүлээн авч, нэгтгэн, УУХҮЯ болон Монгол банканд тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 138.2 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдэл нөөцтэй байгаагаас А-80 автобензин 21 хоног, Аи-92 автобензин 31, дизель түлш 30 хоног, ТС-1 41 хоног, ШШХ 47 хоногийн тус тус үлдэгдэл, нөөцтэй байна. - Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан төлөвлөгөөний дагуу эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын БГД, СБД, СХД зэрэг дүүрэгт байрлах агуулах, шатахуун түгээх станцуудаас түүврийн аргаар 70 дээж авч, чанарын хяналтын шинжилгээ хийж бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажилласан.</p> | 100% |

| | | | | | |
|----|----|--|---|--|------|
| 10 | 11 | Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай 2022-10-19 Дугаар 2022_379 | <p>2. Энэ тогтоолын хавсралтад заасан Эрдэнэтийн стратегийн ордын талбайд ашигт малтмал хайх эрхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т олгох арга хэмжээг авч, ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т үүрэг болгосугай.</p> <p>3. Ашигт малтмал хайх ажлыг гүйцэтгэх төрийн өмчит хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Орхон, Булган аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p> | <p>Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай” 379 дүгээр тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 03/2885 тоот албан бичгийг тус тус үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай” А/135 дугаар тушаал гарсан. Улмаар Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 69 дүгээр шийдвэрээр Засгийн газрын тогтоолын хавсралтаар батлагдсан солбицол бүхий Орхон, Булган аймгуудын Орхон, Баян-Өндөр, Жаргалант, Бугат, Сэлэнгэ, Хангал сумдын нутагт байрших Хужир, Хөх асгат, Согоот, Зөөхийн гол, Ундрах, Оюут нэртэй газруудад ашигт малтмалын хайгуулын XV-022166, XV-022167, XV-022168, XV-022169, XV-022170, XV-022171 дугаартай тусгай зөвшөөрлүүдийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т олгосон болно.</p> | 100% |
| 11 | 12 | Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай 2022-10-19 Дугаар 2022_379 | <p>2. Орхон, Булган аймгийн нутагт ашигт малтмал хайх талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Энэ тогтоолын хавсралтад заасан Эрдэнэтийн стратегийн ордын талбайд ашигт малтмал хайх эрхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т олгох арга хэмжээг авч, ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т үүрэг болгосугай.</p> | <p>Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай” 379 дүгээр тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 03/2885 тоот албан бичгийг тус тус үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай” А/135 дугаар тушаал гарсан. Улмаар Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 69 дүгээр шийдвэрээр Засгийн газрын тогтоолын хавсралтаар батлагдсан солбицол бүхий Орхон, Булган аймгуудын Орхон, Баян-Өндөр, Жаргалант, Бугат, Сэлэнгэ, Хангал сумдын нутагт байрших Хужир, Хөх асгат, Согоот, Зөөхийн гол, Ундрах, Оюут нэртэй газруудад</p> | 100% |

| | | | | | |
|-----------------------------------|----|---|---|--|------|
| | | | ашигт малтмалын хайгуулын XV-022166, XV-022167, XV-022168, XV-022169, XV-022170, XV-022171 дугаартай тусгай зөвшөөрлүүдийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т олгосон болно. | | |
| 13 | | 3. Ашигт малтмал хайх ажлыг гүйцэтгэх төрийн өмчит хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Орхон, Булган аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай” 379 дүгээр тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 03/2885 тоот албан бичгийг тус тус үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай” А/135 дугаар тушаал гарсан. Улмаар Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 69 дүгээр шийдвэрээр Засгийн газрын тогтоолын хавсралтаар батлагдсан солбицол бүхий Орхон, Булган аймгуудын Орхон, Баян-Өндөр, Жаргалант, Бугат, Сэлэнгэ, Хангал сумдын нутагт байрших Хужир, Хөх асгат, Согоот, Зөөхийн гол, Ундрах, Оюут нэртэй газруудад ашигт малтмалын хайгуулын XV-022166, XV-022167, XV-022168, XV-022169, XV-022170, XV-022171 дугаартай тусгай зөвшөөрлүүдийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т олгосон болно. | 100% | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | |
| 12 | 14 | 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 50 дугаар тэмдэглэл 2022-10-19 Дугаар 2022_50 | ҮИ.2. Засгийн газрын 2011 оны 349 дүгээр тогтоолын дагуу автобензин, дизель түлшний улсын нөөц бүрдүүлсэн ажлын явц, түүний зарцуулалт, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа 11 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Ашигт малтмал, газрын | - Монгол Улсын Засгийн газрын Эрсдэлийн сан болон 2012 оны улсын төсвийн хөрөнгөөр нийт 12,7 мян.тн шатахуунаар улсын нөөц бүрдүүлснээс 10,191.6 тонн нь зуны дизелийн түлш, 2,539.6 тонн нь Аи-92 автобензин тус тус байна. Энэхүү улсын нөөцийн шатахууныг Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 68 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам, УУХҮ-ийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн А/91 дугаар тушаалаар баталсан “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээ”-ний үлгэрчилсэн загварын дагуу өөрийн эзэмшлийн агуулах бүхий бүх төрлийн шатахуун импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй НИК, | 100% |

| | | | | |
|--|--|--|---|--|
| | | тосны газар (Л.Баярмандал) нарт даалгав. | Монсуль, Ойн бирж, Магнай трейд, Содмонгол групп, М-Ойл групп, Петрохаан, Газ-Ойл нефть, Тод петролиум, Шинэ эрин ойл, ШТШАБ зэрэг 11 аж ахуйн нэгжтэй “Улсын нөөцийг сэлгэн, хадгалуулах гэрээ” байгуулан хадгалуулж байна. Улсын нөөцийн шатахууны сэлгэн хадгалалтын талаарх мэдээ тайланг гэрээний хавсралт маягтын дагуу сар бүрийн 05-ны дотор аж ахуйн нэгжүүдээс авч нэгтгэн, удирдлагад танилцуулж, тухай бүр УУХҮЯ-нд хүргүүлэн ажиллаж байна. - Тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Улсын нөөцийн шатахууны сэлгэн хадгалалтын талаарх мэдээлэл, холбогдох танилцуулга, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг нэгтгэн боловсруулж, УУХҮ-ийн сайдын 2022.12.16-ны өдрийн 01/3312 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын 2022.12.21-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. | |
|--|--|--|---|--|

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР